


САНАМЖ

- Эхийг уншаад, даалгаврыг зааврын дагуу гүйцэтгээрэй.
- Даалгаврыг 40 минутад гүйцэтгэнэ үү.
- Өгсөн зайд цэвэр гаргацтай бичээрэй.

ГОЛЫН ЖАРААХАЙ

Намар сургуульдаа очихдоо багшдаа бэлэгтэй байя гэж би бодлоо. Багш миний толгойг илж “Яасан сайн хүү вэ!” гээд инээж байна хэмээн төсөөлөв. Тэгээд би “багшдаа талын цэцэг өгье” гэж бодлоо. Ойгоос цээний ягаан цэцэг түүгээд лаазтай шороонд суулгав.



Тэр шөнө ингэж зүүдлэв. Тарьсан цэцгээ хартал цэцэг биш модтой чихэр ургачхаж. Муу нь юу байх вэ? Модтой чихэр багшдаа өгч болно шүү дээ. Гэхдээ би өөрийнхөө тарьсан чихрийг ганцхан удаа долоож үзмээр бодогдов. Долоосон чинь амт нь салахын аргагүй сайхан байна. Дахиад нэг долоомоор.... За яадаг юм бэ? Гурван удаа долооход дуусах юм биш гэж бодогдоод чихрийг их удаан долоолоо. Нэг мэдсэн тагнай уруу юм хатгах шиг болохоор нь шүлсээ залгиад харвал чихэр дуусаж иш нь үлджээ. Одоо яана. Багшдаа өгөх бэлэггүй гэж бодоод уйлав.

Сэрсэн чинь дэр нойтон болжээ. Чийдэнгээ асаан цонхон дээрх цэцгээ харвал хорчийтол хатсан байв. Ёстой уйлахад ч багадахаар юм болжээ.

Маргааш энэ бүхнээ Наранхүүд ярилаа. Наранхүүгийн аав Москвагаас алтан загаснууд авчирч өгсөн гэнэ... Наранхүү намайг өрөвдсөн ч юм уу гэнэт “Дүүрээн! Чамд нэг алтан загас өгье!” гэлээ.

Би устай варианы шилэнд загасаа хийж бариад гүйсээр ирэв. Өвс ногоо, элс, гоё чулуу байхгүй нэг л чамламаар... Ингээд голоос хэдэн жараахай барьж хийв. Шөнө жараахайнуудыг яаж алтан өнгөтэй болгох тухай бодлоо. Гэвч арга олдсонгүй. Гэтэл өглөө юу болсон гээч жараахай минь цөм үхжээ. Ганцхан Наранхүүгийн өгсөн алтан жараахай сэлэн наадаж харагдана.

Би ямар хүн бэ? гэж бодохоос нулимс гүйлгэнэв. Талын цэцэг тасалгаанд хонодоггүй, голын жараахай гоё хоргонд амьдардаггүйг тэгж би мэдсэн билээ. Голын жараахайнууд минь намайг уучлаарай.

Жаргалын Барамсай (Цүнхтэй инээд)

1 “Хорчийтол” гэсэн үг нь өгүүллэгт ямар утга санааг илэрхийлж байна вэ?

- А. Цэцэг өнгө, үзэмжээ алдсан болохыг илэрхийлсэн
- Б. Цэцэг дахин ургах боломжгүй болсныг илэрхийлсэн
- В. Цэцэг усгүй, хуурайшсан болохыг илэрхийлсэн
- Г. Цэцэг алга болсон болохыг илэрхийлсэн

2 Эхийн эхлэл хэсэгт юуны тухай өгүүлсэн бэ?

- А. Хүү цэцэг тариад бүтэлгүйтсэн тухай
- Б. Ойгоос цэцэг түүсэн тухай
- В. Багшдаа талын бэлэг өгөх болсон тухай
- Г. Наранхүү алтан загас өгсөн тухай

3

“Устай варианы шилэнд загасаа хийж бариад гүйсээр ирсэн нь” ямар үйл явдлаас шалтгаалсан бэ?

- А. Наранхүүгийн аав алтан загас авчирч өгснөөс
- Б. Маргааш нь болсон явдлаа Наранхүүд ярьснаас
- В. Цонхон дээрх цэцэг хорчийтол хатсанаас
- Г. Жараахайнуудыг алтан өнгөтэй болгох тухай бодсоноос

4

Цонхон дээрх цэцгээ хорчийтол хатсан байхыг харах үед хүүгийн гадаад дүр байдал ямар байсныг төсөөлөн бодоод бичээрэй.

5

“Голын жараахай” эхийг өөр сургуулийн хүүхдүүд уншсан. Тэд “Наранхүү ганцхан алтан загас өгснөөс болж Дүүрэн голоос жараахай барьсан” гэж үзсэн.

 Чи үүнтэй санал нийлж байна уу? Сонгоорой.

А. тийм Б. үгүй

- Яагаад гэдгээ эхээс жишээ татан тайлбарлаарай.

6

Эхийн эхлэл болон төгсгөл хэсэгт үндэслэн хүснэгтийг нөхөж бичээрэй.

Хүү эхлээд яасан бэ?	Хүү юу ойлгосон бэ?	Яагаад өөрчлөгдсөн бэ?
		Цээнийн цэцэг хорчийтол хатсан.

7

Я, Ё залган бичихдээ “ь” тэмдэг жийрэглэх бүлэг үгийг сонгоорой.

А. дуул, сана,
хар

Б. сор, хар,
дуул

В. уя, зор,
хар

Г. уу, гар,
сор

8

Өгсөн баримтад тулгуурлан “Уриалга” бичээрэй. (50-60 үгтэй)

Цэцэрлэгт хүрээлэн орчмын хогийг цэвэрлэв.
Түүсэн хогоо ангилаад, хүснэгтэд харууллаа.

Цэцэрлэгт хүрээлэн дэх байршил	Дүүргэсэн шуудайны тоо				Нийт
	Лааз 	Усны сав 	Хүнсний сав 	Бусад хог 	
Вандан сандал 	9	5	7	3	24
Тоглоомын талбай 	4	3	10	2	19
Хөл бөмбөгийн талбай 	7	4	2	1	14
Машины зогсоол 	8	23	5	1	37
НИЙТ	28	35	24	7	94 

Хог хөрсөнд задарч шингэх хугацаа

